

JUNE 2020
EDITION N°74

INFLIGHT

FOUR SEASONS

Melody

HIGH-END MEMBERSHIP MAGAZINE



**D.Zagdjav, Deputy Minister of Mining and Heavy Industry:
THE MINERAL RESOURCES SECTOR CONTRIBUTES GREATLY TO
THE ECONOMIC DEVELOPMENT OF OUR COUNTRY**



РЕДАКЦИЙН ЗУРВАС

Эрхлэгч, редактор П.МОНХЖАРГАЛ



**УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН
ДЭД САЙД Д.ЗАГДЖАВ:
ЭХ ОРНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛД
ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАР ОНЦГОЙ
ХУВЬ НЭМЭР ОРУУЛАН АЖИЛЛАЖ БАЙНА**

"Тэвчээрт хязгаар бий. Энэ бол Монголын ард түмний санаа бодлын илэрхийлэл юм. Би "Рио Тинто" компанийг Монголын хөгжилд тодорхой хувь нэмэр оруулахыг шаардаж байна" хэмээн тус компанийг Монголын баялгийг ашиглаж буйн төлөө улсын хөгжилд хөрөнгө оруулалт хийх ёстой гэж, зоригтой дуугарсан Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайд ДЭЛЭГИЙН ЗАГДЖАВ. Тэрбээр Ховд аймгийн Ховд хотод төрж, Ховд хотын 10 жилийн 1 дүгээр дунд сургууль, Нийгмийг аюулаас хамгаалах яамны Цэргийн дээд сургууль, Төрийн захирагааны удирдлагын хөгжлийн институт, Төрийн удирдлагын академи, Оросын Холбооны Улсын Новосибирск хотын Эдийн засагийн удирдлагын улсын академи, Эрхүү хотын Зам харилцааны улсын их сургуулийг тус тус төгссөн, эрх зүйч, эдийн засагч, төмөр замын ашиглалтын инженер мэргэжилтэй, улс төрийн ухааны доктор, ОХУ-ын Батлан хамгаалах, аюулгүй байдал, эрх зүйн академийн профессор, Монгол Улсын Зэвсэгт хүчиний бэлтгэл хурандаа. Дорноговь аймгийн Цагдан сэргийлэх хэлтэс, Ховд аймгийн АДХГЗ-ны дэргэдэх Хууль зүйн арбитрын хэлтэст дарга, Шүүхийн гишүүн, "Алтай интернайшнл" ХХК-ийн Ерөнхий захирал, Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг дарга, Байгаль орчны яамны Төрийн нарийн бичгийн даргаар ажиллаж, 1998-2006 онд Монголын Ардчилсан Социалист Оюутны Холбооны Ерөнхийлөгч, 2008-2012 онд Монгол Улсын Их Хурлын гишүүнээр тус тус сонгогдон, Улсын Их Хурлын Нутгийн удирдлагын дэд хорооны даргаар ажиллаж байсан, 2013 оноос Монголын Энх тайван, найрамдлын байгууллагын Ерөнхийлөгчөөр, 2017 оноос Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайдар томилогдон ажиллаж байна.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайд Д.Загджавтай салбарын хүрээнд тулгамдсан, шийдвэрлэж буй асуудлуудын талаар ярилцлаа.

"Patience has its limits. This is the expression of the thoughts and opinions of the Mongolian public. I call for Rio Tinto to contribute to the development of Mongolia". These are the words of Zagdjav Deleg, Deputy Minister for Mining and Heavy Industry, who has bravely said that the company must invest in the development of Mongolia for the mining of mineral resources in the country. He was born in Khovd city, Khovd aimag, where he finished the secondary school no 1. Then he went on to study at the Military Institute, affiliate of the Ministry of Defense, the Management and Development Institute for State Administration, the State Management Academy, the State Economic Management Academy in Novosibirsk city, Russian Federation, the State University for Road and Infrastructure in Erkhuu city. He is qualified as an economist, lawyer and railway management engineer and his titles include; Doctor of Political Science; Professor of Defense, Security and Law Academy in the Russian Federation; and Lieutenant Colonel of the Mongolian Armed Forces. Professional work experiences include: Head of Police Department in Dornogobi aimag; Head of Law and Arbitration Department of the АДХГЗ, Khovd aimag; Member of Court; General Director of Altai International LLC; Governor of Khan-Uul District, Ulaanbaatar; State Secretary at the Ministry for Environment; President of the Mongolian Socialist Students' Association from 1998-2006; Member of Parliament from 2008-2012; Head of Local Management Sub-committee of the State Ikh Khural; President of the Mongolian Peace and Friendship Organisation from 2013 to date and the Deputy Minister of Mining and Heavy Industry since 2017..

We have discussed with D.Zagdjav, Deputy Minister for Mining and Heavy Industry about the urgent but crucial issues in the sector.



-Уул уурхайн салбарт хэрэгжүүлсэн томоохон арга хэмжээ болон хийгдэж буй ажлын талаар ярилцлагаа эхэлье?

- Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудалд инженерчлэлийн чиглэлийн геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тос гэсэн 4 салбар хамаардаг. Монгол Улсын Засгийн газраас салбарын хууль, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, ашигт малтмалын хайгуул, олборлолтын үйл ажиллагааг эрчимжүүлэх, стратегийн ордын үнэ цэнийг өсгэх, дотоодын түүхий эдийн нөөцед тулгуурлан газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээг хангах боломж, нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн бодлогын зорилтуудыг тавин ажиллаж байна. Энэ хүрээнд Ашигт малтмалын тухай, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай зэрэг гол хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулж, хуулиудын давхардал, хийдэл, зөрчлийг тогтоон холбогдох хуулийн төслүүдийг боловсруулсан. Ингэснээр ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөх зохицуулалт тодорхой болж, хууль бус ашигт малтмал олборлох үйл ажиллагаа буурч, үүсмэл орд ашиглах эрх зүйн орчин бүрдсэн зэрэг бодлогын томоохон шийдлийг гаргалаа.

Мөн Үндэсний геологийн алба байгуулах асуудал болон "Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого", "Үндэсний гео мэдээлийн сан хөтөлбөр", "Хүнд үйлдвэрийн хөгжлийн хөтөлбөр"-ийг УИХ, Засгийн газраар батлууллаа. Үндэсний геологийн албыг сэргээн байгуулснаар геологийн судалгаа, шинжилгээ хийх, мэдээлэл боловсруулах, хадгалах үйл явцыг нэгдсэн удирдлагаар хангах боломж бүрдлээ. "Алт-2" үндэсний хөтөлбөрийн хүрээнд 53.4 тонн алтны нөөцийг Улсын нөөцийн нэгдсэн санд шинээр бүртгүүлж, 2016-2019 онд 75.4 тонн алтыг Монголбанкинд тушаасан. Хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох болсноор улсын төсөвт 32.8 тэрбум төгрөг төвлөрүүлсэн.



-We would like to start our interview with the substantial measures and ongoing works in the mining sector?

- The Minister for Mining and Heavy Industry is responsible for 4 main sectors of geology, mining, heavy industry and petroleum. The goals of the Government of Mongolia are to improve the sector's legal environment, intensifying mineral exploration and mining, increasing the value of strategic deposits and to create opportunities and conditions to meet the consumption of petroleum products based on domestic commodity resources . As part of this, amendments to key laws such as the Law in Minerals and Law on Monitoring the Circulation of Explosives and Explosive Devices have been made. Also, we have identified duplications, gaps and violations in the sector's laws and have prepared their drafts. These have resulted in making substantial policy decisions for clearer regulations for mineral royalty payments, reducing illegal mining activities and favorable legal conditions for the use of derivative deposits.

In addition, the issue of forming a National Geological Agency, "The State Policy on Developing the Petroleum Sector", "The National Geo-Database Program" and "The Development Program for the Heavy Industry" have been respectively approved by Parliament and the Government. The reforming of the National Geological Agency gives us the opportunity to provide centralised management for conducting geological surveys and researches, data processing and storing. As part of the "Gold-2" National Program, a total of 53.4t gold were newly registered in the Central State Reserves Fund. In 2016-2019, 75.4t gold were commissioned to the Bank of Mongolia. The issuance of exploration licenses through selection has brought 32.8B MNT to the state budget.

In 2019, feasibility studies for 191 mines and mining plants were discussed for decision, 70 mines and mining plants were commissioned for operation and many important measures were taken to create new local jobs, increase exports and to strengthen the economic capability. The mining sector in Mongolia solely represents 24% of the gross



Япон Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Токанори Шимизуг нутаг буцаж байгаатай нь холбогдуулан хүлээн авч уулзав. 2018.11.28

өнгөрсөн 2019 онд 191 уурхай, уулын үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл /ТЭЗҮ/-ийг хэлэлцэн шийдвэрлэж, 70 уурхай, уулын үйлдвэрийг байнгын ашиглалтад хүлээн авч, орон нутагт ажлын байрыг шинээр бий болгох, экспортыг нэмэгдүүлэх, эдийн засгийн чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн олон чухал арга хэмжээг авч хөрөгжүүллээ.

Монголын уул уурхайн салбар дотоодын нийт бүтээгдэхүүний 24 хувь, аж үйлдвэрийн бүтээгдэхүүний 73 хувь, экспортын бүтээгдэхүүний 90 хувь, гадаадын шууд хөрөнгө оруулалтын 75 хувийг дэнгаар бүрдүүлж, улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд голлох үүрэг гүйцэтгэж байна.

“АЙМАГ ОРОН НУТАГТ ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙ, ГАЗРЫН ТОСНЫ АСУУДАЛ ХАРИУЦСАН НЭГЖ БАЙГУУЛЖ АЖИЛЛАХЫГ ЦАГ ҮЕ ШААРДАЖ БАЙНА”

-Энэ 2020 оны бодлогын гол зорилт юу байх вэ?

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрлэлийн салбарын хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн тогтолцоог бий болгох зорилтын хүрээнд эрдэс баялгийн салбарын хөгжлийн 2050 он хүртэлх бодлогын зорилтыг тодорхойлсон. Ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх, эрдэс баялгийн сан хөмрөгийг аврижуулах замаар тогтвортой, олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгох зорилтын хүрээнд 2020 онд: 19.0 тн алт, 42.0 сая тн нүүрс, 6.6 сая баррель газрын тос, 1.2 сая тн зэсийн, 8.3 сая тн төмөрийн баяжмал экспортод гаргаж, улсын төсөвт 3.2 их наяд төгрөгийн орлого төвлөрүүлэхээр ажиллаж байна.

-Юуны өмнө салбарын голлох хуулиудыг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй нийцүүлэх, түгээмэл тархацтай ашигт малтмал болон бичил уурхайгаар ашигт малтмал олборлохтой холбоотой эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, газрын хэвлэлийн судалгаа, ашиглалтын

domestic product, 73% of the industrial products, 90% of the export products as well as 75% of the foreign direct investment thus taking taking a lead role in the social and economic development of the country.

“THIS IS THE TIME TO HAVE GEOLOGICAL, MINING AND PETROLEUM UNITS IN AIMAGS”

-What is the main policy goal in the year of 2020?

The Ministry of Mining and Heavy Industry has defined the policy goals until the year of 2050 for the development of the mineral sector as part of its aims for creating a central policy and planning system for the development of the geological, mining and petroleum sectors.

As part of the goals for creating a sustainable and multi-faceted economy by way of developing responsible and transparent mining and enriching the mineral fund, we are aiming to export 19.0t gold, 42.0 Mt coal, 6.6 Mb oil, 1.2 Mt copper, 8.3 Mt iron concentrate to bring in 3.2T MNT to the state budget in 2020.

-First of all, we will focus on updating the main laws for the sector to comply with the amendments to the Constitution, improving the legal conditions in relation to common mineral and artisanal mining, enhancing the regulations for soil survey and use, updating and improving relevant rules, procedures and standards, publicly offering certain percents of the shares in the strategic deposits internationally and strengthening the cooperation between license holders and local administrations.

For instance, the Minister for Mining and Heavy Industry signs contracts with the governors of all 21 aimags every year and ensures their implementation. A conclusion is issued for the artisanal mining of minerals in 272 unit areas covering a total of 1113.4 ha in 21 aimags. Establishing of such units have respective advantages such as spreading awareness about the legal conditions and the state policies in the sector, providing the local management with professional know-how, eliminating the misunderstanding between local population and bringing the state services closer to businesses.

үйл ажиллагааны зохицуулалтыг боловсронгуй болгох, холбогдох дүрэм, журам, стандартыг шинэчлэх, боловсронгуй болгох, стратегийн зарим ордын хувьцааны тодорхой хувийг олон улсад нээлттэй арилжаалах, тусгай зөвшөөрөл эзэмшигч болон нутгийн захиргааны байгууллага хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд анхаарал хандуулна.

Тухайлбал, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд 21 аймгийн Засаг даргатай жил бүр гэрээ байгуулан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. 21 аймгийн хэмжээнд 1113.4 га талбай бүхий 272 нэгж талбарт бичил уурхайгаар ашигт малтмал олборлох дүгнэлт гаргаад байна. Уг нэгжийг байгуулсаны салбарын хууль эрх зүйн орчин, салбарын талаар төрөөс баримтлах бодлогыг таниулах, орон нутгийн удирдлагыг мэргэжил арга зүйгээр хангах, орон нутгийн иргэдийн ойлголтын зөрүүг арилгах, аж ахуйн нэгжүүдэд төрийн үйлчилгээг ойртуулах зэрэг ач холбогдолтой.

-Уул уурхайн салбарт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн томоохон төслийн ажлын явц ямар байна вэ?

-Оюу толгойн ордыг түшиглэн Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт барихаар төлөвлөсөн "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр"-ийн төслийн хүрээнд урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл болон байгаль орчны ерөнхий үнэлгээг боловсруулж, холбогдох байгууллагын дүгнэлтийг гаргуулсан. Тус үйлдвэр жилд нэг сая тонн зэсийн баяжмал боловсруулан 257 млн.тонн зэс, зургаан тонн алт, 57 тонн мөнгийг яланг авч, дагалдах байдлаар 988 млн.тонн хүхрийн хүчлийг үйлдвэрлэнэ.

Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт баригдаж байгаа "Газрын тос боловсруулах үйлдвэр"-ийн дэд бүтцийн бүтээн байгуулалт болох Сайншанд чиглэлийн 27 км урт төмөр зам, 18.2 км урт 110 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, 16.6 км урт хатуу хучилттай авто замын барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн. Засгийн газраар үйлдвэрийн болон ахуйн хэрэгцээнд шаардлагатай усны асуудлыг шийдвэрлүүлсэн. Газрын тос боловсруулах үйлдвэр ашиглалтад орсноор газрын тосны бүтээгдэхүүн авто бензин, дизель тулшиний хэрэглээг дотоодын үйлдвэрлэлээр хангаж, импорт 1.0 тэрбум гаруй ам.доллараар буурч, мөн хэмжээгээр гадаад худалдааны орлого нэмэгдэнэ. "Алт цэвэршүүлэх үйлдвэр"-ийн ТЭЗҮ-г Эрдэс баялагийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж хүлээн авсан. Хүнд үйлдвэрийн хөгжлийн хөтөлбөр хэрэгжсэнээр боловсруулах үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдэж, тухайлбал, цэвэр зэс үйлдвэрлэл 1.6 дахин, зэс утасны үйлдвэрлэл хоёр дахин есч, нэмүү өртөг шингэсэн шинэ үйлдвэрүүд бий болж, эдийн засгийн бүтцэд томоохон өөрчлөлт гарна. Ган бүтээгдэхүүний үйлдвэрлэл есч, ган бөмбөлөг, ган туйван, ган утас зэрэг гол нэр төрлийн ган бүтээгдэхүүний дотоодын хэрэгцээг хангана. Таван толгойн коксих нүүрсний бүлэг ордыг холбогдох дэд бүтцийн хамт иж бүрнээр нь ашиглахаар ажиллаж байна. Зүүнбаян-Гашуунсухайт, Таван толгой-Гашуунсухайтын төмөр замын ажлыг эхлүүлсэн.

"ТАВАН ТОЛГОЙН БҮЛЭГ ОРДЫН ЗҮҮН ЦАНХИЙН ХЭСГИЙГ ОЛОН УЛСЫН БИРЖИД ГАРГАЖ ХӨРӨНГӨ БОСГОЖ НЭМҮҮ ӨРТӨГ ШИНГЭСЭН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭХ АЖЛЫГ ЭРЧИМТЭЙ ГҮЙЦЭТГЭЖ БАЙНА"



-What are the stages of implementation of the big projects planned?

-As part of the project to build Copper Concentration Plant based on the Oyu Tolgoi mine, in Khanbogd sum, Umnugobi aimag, the preliminary feasibility study and the general environmental assessment are already prepared, and the conclusions are obtained by a relevant organisation. The plant will have the annual copper concentrate processing capacity of 1 Mt, and the annual separation capacity of 257 Kt copper, 6 t gold and 57 t silver. It will produce 988 K sulfuric acid as a by-product. The construction works of the 27km railway, the 18.2km long 110kW overhead electricity line, the sub-station and the 16.6km asphalt road to Sainshand, all of which are the ongoing infrastructural developments for the oil refinery in Altanshree sum, Dornogobi aimag, are all finalised. The issue for the industrial and domestic water use is resolved by the Government. Following the commissioning of the oil refinery, the petroleum products such as fuel and diesel will be supplied domestically to reduce the import by about 1 billion MNT. At the same time, the income from the foreign trade will increase. The feasibility study of the Gold Refinery Plant is approved by the Professional Mineral Council. The implementation of the heavy industry development program will help increase the processing capacity. For instance, pure copper production will go up by 1.6, production of copper wire will double, and subsequently, plants with added value will become newly operational to bring substantial changes in the economy. The steel product manufacturing will expand to supply the domestic needs for the main steel products such as steel pellets, rods and wires. We are working on developing the Tavan Tolgoi coking coal group deposits with required infrastructures. The construction works of the Zuunbayan-Gashuunsukhait and the Tavantolgoi-Gashuunsukhait have commenced.

"THE WORKS FOR THE LISTING OF THE ZUUN TSANHI OF THE TAVANTOLGOI GROUP DEPOSITS AT AN INTERNATIONAL STOCK EXCHANGE ARE ONGOING TO RAISE FUNDING FOR THE PRODUCTION OF VALUE ADDED PRODUCTS"

-Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтээс зорилгоо бүрэн хүрээгүй арга хэмжээ байгаа юу? Шалтгаан нь юу вэ?

-Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг боловсруулах, Газрын хэвлэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах, Уурхайн дэд бүтцийн хөгжлийн урт хугацааны төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах, Тавантолгойн ордыг иж бүрэн ашиглах төслийг боловсруулж, хэрэгжүүлэх, Цагаан суварга төслийг хэрэгжүүлэх, Дархан, Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолбор байгуулах нөхцөлийг бүрдүүлэх зорилтын хүрээнд шууд ангижруулсан төмөрийн үйлдвэр байгуулах, гангийн үйлдвэрийн өргөтгөл хийж, хүчин чадлыг нь нэмэгдүүлэх арга хэмжээнүүд төлөвлөгөөний зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй. Дархан, Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолбор байгуулах нөхцөлийг бүрдүүлэх зорилтын шууд ангижруулсан төмөрийн үйлдвэр байгуулах, гангийн үйлдвэрийн өргөтгөл хийж, хүчин чадлыг нь нэмэгдүүлэх 2 арга хэмжээний хүрээнд "Уул уурхай хар төмөрлөгийн цогцолбор" байгуулах төслийн хөрөнгө оруулалт шийдэгээгүй улмаас бүтэн байгуулалтын ажил хугацаандаа хийдэгээгүй байна.

-Монгол Улсын эдийн засаг уул уурхайн салбараас хэт их хамааралтай байна гэдэг шүүмжлэл бий. Яг бодит тооцооллоор уул уурхайн салбар өнөөдөр Монголын эдийн засгийн хэдэн хувийг эзэлж байна вэ?

-2019 оны урьдчилсан гүйцэтгэлээр уул уурхайн салбар дотоодын нийт бүтээгдэхүүний 25 хувь, аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 72 хувь, экспортын 90 хувийг тус бүрдүүлж байна. 2019 оны урьдчилсан гүйцэтгэлээр 50.83 сая тонн нүүрс, 1.26 сая тонн зэсийн баяжмал, 16.25 тонн алт, 5.30 млн.тонн молибдений баяжмал, 156.15 млн.тонн хайлуур жоншны худэр, 47.49 млн.тонн хайлуур жоншны баяжмал, 8.57 сая тн төмөрийн худэр, 3.39 сая тн төмөрийн худрийн баяжмал, 83.09 млн.тн цайрын баяжмал тус тус үйлдвэрлэсэн байна. Өнгөрсөн оны мөн үеийн харьцуулахад нүүрс 824.44 сая тн буюу 1.6 хувь, төмөрийн худэр 2.35 сая.тонн буюу 37.7 хувь, хайлуур жоншны худэр 54.98 млн.тонн буюу 54.3 хувиар тус тус өссөн байна. Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого 2019 оны гүйцэтгэлээр 11.9 их наяд төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 1.9 их наяд төгрөг буюу 18.6 хувиар өссөн байна. Эрдэс баялагийн салбар нь Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогын 24.5 хувийг бүрдүүлж байна. 2019 оноос Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.7-д "ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогоос 2019 оны төсвийн жилд 50 хувь, 2020 оны төсвийн жилээс эхлэн 100 хувь, 2020 оны төсвийн жилээс эхлэн ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогын 50 хувь"-ийг тус тус Орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлэхээр байна.

-Монгол Улс далайд гарцгүй орон, одоогоор уул уурхайн бүтээгдэхүүнээ хэрхэн экспортолж байна вэ? Тяньжин боомтыг ашиглах нэг хувилбар яригдаж байсан талаар мэдээлэл байна. Одоо өөр хувилбар яригдаж байгаа юу. Тус төслийг хэрэгжүүлэхэд БНХАУ-ын тавьж буй голлох нөхцөлүүд нь юу байв?

-Манай улс хойд талаараа ОХУ, өмнөд талаараа БНХАУ-тай хил залгаа оршдог. Уул уурхайн бүтээгдэхүүний борлуулалт гол төлөв

-Are there any measures in the Government Action Program for 2016-2020 which are not fully implemented to reach the goals? What are the reasons?

-The measures for the drafting of the Law on Transparency in the Mineral Sector, the updating of the Law on Subsoil, the document preparation of the long-term development planning of the mining infrastructure, the developing of the Tavantolgoi deposit, implementing of the Tsagaan Suvarga project, the building of a metallurgical plant (as part of providing the opportunity to build ferrous metallurgical complex) in Darkhan and Selenge regions, and the extention of the steel plant to improve its manufacturing capacity have not been fulfilled as had been targeted. The investment issue for the Mining and Metallurgical Plant development project, as part of the two measures such as the building of a metallurgical plant to provide the opportunity to build ferrous metallurgical complex in Darkhan and Selenge regions, and the extention of the steel plant to improve its manufacturing capacity, was not resolved, and therefore, delayed their development in the planned timeframes.

-There is a widespread criticism about the Mongolian economy to be dependent on the mining sector. Realistically, what percent does the mining sector count for in the Mongolian economy?

-The preliminary performance for the 2019 shows that the mining sector accounts for 25% of the gross domestic product, 72% of the total industrial product and 90% of the export products, respectively. According to the preliminary performance for 2019, 50.83 m/t coal, 1.26 Mt copper concentrate, 16.25 t gold, 5.30 Mt molybdenum concentrate, 156.15 Mt flouspar ore, 47.49 Mt flouspar concentrate, 8.57 Mt iron ore, 3.39 Mt iron ore concentrate and 83.09 Mt zinc concentrate were respectively produced. In comparison to the same period last year, the production of coal by 824.44 Mt or 1.6%, iron ore by 2.35 Mt or 37.7% and flouspar ore by 54.98 Mt or 54.3% increased respectively.



Зүүн Өмнөд Азийн орнуудын Энх тайвны дээд хэмжээний хурал, Хятадын Коммунист Намын Төв Хорооны Олон улсын газрын орлогийн Төрийн Думын гишүүн, Энх тайвны Сангийн тэргүүн А.Карпов нарын хамт 2014.09.24



ОХУ-ЫН ЕРӨНХИЙЛӨГЧ В.В.ПУТИНТЭЙ НӨХӨРСГӨӨР ЯРИЛЦАЖ БАЙГАА НЬ, УЛААНБААТАР ХОТ,
2014.09.03

урд хөршдөө түшиглэн явагдаж байна. Гуравдагч зах зээлд уул уурхайн бүтээгдэхүүнийг экспортлоход зайлшгүй хөрш хоёр ороороо дамжуулан тээвэрлэх шаардлага тулгарна. Иймд зам тээврийн дотоод эх үүсвэрийг бүрдүүлэхээс гадна дамжуулан тээвэрлэх нэхцэлийн хөрш орууздтайгаа ярьж тохиолцох шаардлагатай. Уул уурхайн салбарын хөгжилд гадаад болон дотоодын шууд хөрөнгө оруулалт маш чухал ач холбогдолтой гэж бид үздэг. Манай улс газрын хэвлэлийн болон газрын хөрсөн дээр арвин нөөц баялагтай. Газрын хэвлэлийн хувьд улсын нөөцийн нэгдсэн бүртгэлд ашигт малтмалын 1950 орд, 8150 илрэл бүртгэгдээд байгаагас 300 орчим орд газрыг ашиглан 50 мянга гаруй уурхайчид ажиллаж байна. Жишээ татахад зэс, нүүрс, жоншны нөөцийн хэмжээгээрээ Монгол Улс дэлхийн эхний аравт орохоор түвшинд байна.

-Уул уурхайн салбарт байгаль орчны нөхөн сэргээлтэй холбоотой асуудлууд байдаг. Монгол Улсын хувьд энэ хүндэтлэй асуудлыг хэрхэн тэнцвэржүүлж эдийн засгийн өсөлттэй уялдуулж ажиллаж байна вэ?

-Хууль зүйн үндэслэлийн хүрээнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны А/88 дугаар тушаалаар "Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журам"-ыг боловсруулах үүрэгтэй Ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсэгт холбогдох төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдүүлсэн. Ажлын хэсгээс "Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журам"-ын төслийг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулсан. Журмын төслийг эцэслэн боловсруулж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн А/181, А/458 дугаар хамтарсан тушаалаар батлуулж Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 4530 дугаарт бүртгүүлсэн. Нөхөн сэргээлтийн зардлын 50 хувийг барьцаа болгож Байгаль орчин, аялал жуулчлалын яамны дэргэдэх тусгай дансанд байршуулдаг. Мөн жил бүрийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын яам батлан, тайланг хүлээн авч нөхөн сэргээлтийн ажилтай холбоотой асуудлыг хариуцаж ажилладаг.

By the 2019 performance, the budget revenue of Mongolia went up to 11.9 trillion MNT to see an increase of 1.9 trillion MNT or 18.6% compared to the same period last year. The mineral sector accounts for 24.5% of the budget revenue generation in Mongolia. From the year 2019 and as has been stated in Clause 60.2.7 of Article 60 of the Budget Law "... 50% from the income of the mineral exploration license fees for the Budget Year of 2019, 100% from the Budget Year of 2020, and from the year of 2020, 50% from the income of the mineral mining license fees for the Budget Year 2020..." will be allocated to the Local Development Fund.

-Mongolia is a landlocked country. How are the mining products exported? Tianjin port is said to be an option? Are there any other options? What are the main conditions by People's Republic of China for implementing this project?

Our country borders the Russian Federation in the north and the People's Republic of China in the south. The sales of our mining products are mostly done with our southern neighbor. Transportation through the two neighboring countries is inevitable to export the mining products to tertiary markets. Therefore, in addition to creating domestic transportation sources, there is also a need to negotiate with our neighboring countries on the terms of transit. We think that direct domestic and foreign investment is of great importance in the development of the mining sector. Our country has abundance of mineral resources on and under the soil. As for the subsoil, 1950 mineral deposits and 8150 mineral occurrences are registered in the state central reserve registration, out of which 300 deposits are in operation with employment of about 50.000 miners. For example, Mongolia is amongst the first ten countries in terms of its copper, coal and fluospar mineral reserves.

-There are issues related to environmental reclamation in the mining sector. How is Mongolia, as a country, balancing this difficult issue to coordinate with its economic growth?

-Based on legal grounds, a Working Group was formed, under the Resolution A/88 of 2017 of the Minister for Mining and Heavy Industry, to be responsible for developing a "Procedure on reclamation and closure of mine and mining/processing plant". The Working Group was formed with representatives from relevant state and non-governmental organisations. The Working Group developed the draft for the "Procedure on reclamation and closure of mine and mining/processing plant" in compliance with applicable international standards. The draft of the Procedure was finalised for approval by and under the joint Resolution A/181 and A/458, dated August 28, 2019, of the Minister for Mining and Heavy Industry and the Minister for Environment and Tourism, and was registered, Registration no 4530, in the State Central Registration of Administrative Acts. The 50% of reclamation costs are placed as collateral in a special account of the Ministry of Environment and Tourism. In addition, the Ministry of Environment and Tourism approve annual environmental management plans and receive relevant reports. It is also responsible for issues related to reclamation.

-Could you, please, share your thoughts about the Belt and Road Program. What are expected following its influence in Mongolia, especially in the mining and infrastructural sectors as well as the direct connections with Central Asia, China and Russia.

-Бүс ба зам хөтөлбөрийн талаар та өөрийн бодлоо хуваалцахгүй юу. Мөн Монгол Улс, тэр дундаа уул уурхай, дэд бүтцийн салбарт нөлөөлсөөр Төв Ази, Орос болон БНХАУ-тай шууд холбогдоноор ямар нөлөө үзүүлэх хулээлт байна вэ?

-БНХАУ-ын Бүс ба зам, Монгол-Хятад-Оросын Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр, зэрэг хөгжлийн стратегийн хүрээнд бүс нутгийн дэд бүтэц, эдийн засгийн интеграцад нэгдэж, бүс нутгийн орнуудтай илүү нягт хамтран ажиллах боломж бүрдүүлэхээр яриа, хэлцлийг өрнүүлж байна. Энэ хүрээнд ОХУ-ас БНХАУ-д нийлүүлэх хийн хоолойн бүтээн байгуулалтыг Монгол Улсын газар нутгаар дайруулах, Монгол Улсын төмөр зам, авто замын төслүүдийг эрчимжүүлэх, дамжин өнгөрөх тээврийн холбогдох хэлэлцээрүүдийг эрчимжүүлэх ажлуудын яриа хэлцлийг эхлүүлсэн. Тухайлбал, Улаанбаатар хотноо 2018 оны зургадугаар сард 25 жилийн хугацаанд хүчин төгөлдөр мөрдөх "Төмөр замаар дамжин өнгөрөх ачаа тээвэрлэх нэхцэлийн тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-т гарын үсэг зурсан нь уул уурхайн бүтээгдэхүүний зах зээлээ өргөжүүлэх боломжийг олгоно гэж үзж байна. Мөн 2014 онд Монгол Улс, Хятад улсын нутаг дэвсгэрээр далайд гарах болон буцах, дамжин өнгөрөх тээвэр хийх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрт гарын үсэг зурагдсанаар Монгол Улсын ашиглах нэр заасан далайн боомтын тоог нэмэгдүүлж, Хойд Хятад болон Зүүн Хойд Хятадын бүс нутгийн гадаад худалдаанд нээлттэй Дандонг, Далиен, Жинъкоу, Ингкоу, Цинь Хуангдао, Хуанг Хуа, Тяньжин зэрэг нийт долоон боомтыг ашиглахаар болсон. Үүнээс гадна УИХ-ын 2018 оны 73 дугаар тогтоолын хүрээнд төмөр зам, авто зам, цахилгаан станц барих, усны нөөцийн асуудлыг шийдвэрлэх ажлууд хийгдэх болно. Тухайлбал, Таван толгой-Гашуунсухайт, Таван толгой, Зүүнбаян, Таван толгой-Оюу толгой-Ханги чиглэлийн төмөр зам, авто замын төслүүд хэрэгжиж, цахилгаан станц барих алжыг эхлүүлэх шийдвэрүүдийг Засгийн газраас гаргасан.

"ДЭД БҮТЦИЙН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭСНЭЭР МАНАЙ УЛСЫН УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛ ӨРГӨЖИЖ, УЛМААР АШИГТ МАЛТМАЛЫН ОРДУУДЫН ҮНЭ ЦЭНИЙГ ӨСГӨХ БОЛОМЖИЙГ БҮРДҮҮЛНЭ"

-Газрын тосны тухай хууль хэрэгжик эхэлснээс хойш 30 орчим жилийн хугацаанд нутаг дэвсгэрийн 30 гаруй хувьд газрын тосны геологийн судалгаа ажил хийгдсэн гэдэг. шинээр баригдах газрын тосны боловсруулах үйлдвэрийг тасралтгүй ажиллах, дотоодын хэрэгцээгээ хангах үйлдвэрийн түүхий эд газрын тосны бэлтгэгдсэн үү?


-УИХ-ын 2016 оны сонгуулийн дараа Засгийн газрын бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтөөр сайдын эрхлэх асуудлын хүрээнд өмнөх бүтцийн Ашигт малтмалын газар, Газрын тосны газар хоёр агентлагийг нэгтгэн зохион байгуулсан, "Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар 2027 он хүртэл баримтлах бодлого"-ыг боловсруулан баттуулсан, геологийн судалгааны ажлын үр дүнгээр шинээр баригдах газрын тосны боловсруулах үйлдвэрийг

-As part of the development strategies such as the Belt and Road Program (Initiative) and the China-Mongolia-Russia Economic Corridor Program, dialogues and negotiations are ongoing to be a part of the regional infrastructure and the economic integration to have the opportunity to closer cooperate with the countries in the region. Within the framework of this, dialogues and negotiations have started in relation to the development projection of the pipeline to run through the territory of Mongolia for delivering natural gas from Russia to China and the intensifying of the railway and road projects in and the transit transport through Mongolia. For instance, the signing of the "Intergovernmental agreement between the Government of Mongolia and the Government of Russian Federation on terms for rail freight transit transportation", effective for 25 years, in June 2018, is considered to be an opportunity for the economic expansion. Furthermore, the signing of the "Intergovernmental agreement on facilitating transport to and from the See Ports in and the transit transport through the territory of China" in 2014, increased the number of the see ports to be used by Mongolia. The 7 see ports such as Dandong, Dalian, Jingzhou, Ingkou, Zing Huangdao, Huanghua and Tianjin, which are open for the foreign trade in the northern and northeastern regions in China. In addition, as part of the Resolution 73 of 2018 of the Parliament, decisions will be made for the railway, road and thermal station construction and development as well as for resolving the water resources. For example, the Government has made decisions for implementing the railway and auto road construction projects for Tavantolgoi-Gashuunsukhait, Tavantolgoi, Zuunbayan and Tavantolgoi-Oyutolgoi-Khangi as well as for commencing the construction development of the thermal station.

"BY IMPLEMENTING THE INFRASTRUCTURAL DEVELOPMENT PROJECTS, THE MARKETS FOR THE MINING PRODUCTS OF OUR COUNTRY WILL EXPAND TO FURTHER INCREASE THE VALUE OF THE MINERAL DEPOSITS"

-The geological survey for petroleum has been conducted in 30 percent of the territory in the country for 30 years since the Petroleum Law had come into effect. Is there sufficient resource of raw materials to supply the newly planned plant to ensure the smooth running of its operation?

-After the 2016 parliamentary election and as part of the areas of responsibility of the minister following the re-structure of the Government, the Mineral Resources Authority and the Petroleum Authority merged. The "State Policy on Development of Petroleum Sector until 2027" was approved. Based on the results of the geological survey, the petroleum resource has been prepared to supply the plant to ensure its continuous running of its operation. Moreover, the issue of founding a National Geological Agency had been in discussion since 1994, and was stated in applicable laws and policy documents of the sector in 2014. However, little progress has so far been made. The issue was respectively discussed in the Cabinet Meeting in October 2019 and in the State Ikh Khural Session in 2020 for approval. The processes of conducting a geological survey are separated to be stated in many different laws such as the Law on Subsoil, the Minerals Law, the Petroleum Law and the Law on Nuclear Energy. This tends to lead



"Олон Улсын энх тайван, аюулгүй байдал, хамтын ажиллагааг бэхжүүлэхэд Монгол Улс, БНХАУ, ОХУ-ын оролцоо" сэдэвт Улаанбаатарын уулзалт, Улаанбаатар хот, 2015.06.18

тасралтгүй ажиллах түүхий эдээр хангах газрын тосны нөөц бэлтгэгдсэн. Түүнчлэн Үндэсний геологийн алба байгуулах асуудал 1994 оноос яригдаж, салбарын хууль, бодлогын баримт бичгүүдэд 2014 онд тусгагдсан ч тодорхой ахиц мутай байсан. Энэхүү асуудал нь Засгийн газрын хуралдаанаар 2019 оны аравдугаар сард, УИХ-ын чуулганаар 2020 онд тус тус хэлэлцэгдэж, дэмжигдсэн. Геологийн судалгааны ажлыг хэрэгжүүлэх үйл явцыг Газрын хэвлэлийн тухай, Ашигт малтмалын тухай, Газрын тосны тухай, Цэнийн энергийн тухай зэрэг олон хуульд салгаж тусгаснаас болж тэр нь хайгуулын ажлын эцсийн үр дүн болоод улс орны эдийн засагт сөрөг нөлөөлөл үзүүлэх хандлага бий болдог. Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан Газрын хэвлэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Эрдэс баялагийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг боловсруулж, төрийн бодлого төлөвлөлтөд шинжлэх ухааны суурь мэдээлэл бэлтгэх Үндэсний геологийн алба байгуулах асуудлыг Засгийн газрын хуралдаан, УИХ-ын чуулганаар тус тус хэлэлцүүлсэн. Салбарын онцлог, мэргэжлийн үйл ажиллагаа, төрийн, төрийн бус байгууллага, салбарын хуулийн этгээд, мэргэжлийн боловсон хүчиний эрх, үүрэг, хариуцлага зэрэг эрх зүйн зохицуулалт бүхий геологи, уул уурхай, кадастр бүртгэл, хөдөлмөр аюулгүй ажиллагааны зэрэг багц хуультай болох замаар салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгож, тулгамдсан асуудлуудыг уе шаттайгаар шийдвэрлэх боломжтой гэж үзж байна.

-Оюу толгойн зэс алтны орд, Асгатын мөнгө, Гацууртын алт, Салхитын мөнгөний орд зэрэг ордуудыг ашиглах талаар олон нийт харилцан адилгүй ойлголттой, зарим нутгийн иргэд, иргэний нийгмийн хөдөлгөөнийхэн ашиглахыг эрс эсэргүүцдэг?

-Ашигт малтмалын ордыг нээн илрүүлж, эдийн засгийн эргэлтэд оруулан ашиглах хүртэл зураглал, эрэл, хайгуул гэсэн геологийн үе шаталсан судалгааны ажилд 20-30 жилийн хугацаа, их хэмжээний хөрөнгө зарцуулж, салбарын инженер техникийн ажилтан, ажиллагсад ажилтай, цалин орлоготой байдаг. Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн жилийн төлбөр, техник эдийн засгийн тооцоо хийгдсэн ордуудыг ашиглан олборлож борлуулсан төлбөр зэрэг нь улсын төсвийн орлого бүрдүүлэлтийн дийлэнх хувийг эзэлдэг. Улсын төсөвт төвлөрүүлсэн орлогыг өндөр настны

to negative effects to the final results of the geological works and the economy of the country. As stated in the Government Action Program for 2016-2020, the updates to the Law on Subsoil and the Law on Transparency in the Mineral Sector were made to be discussed in the Cabinet Meeting and the State Ikh Khural session together with the issue to found a National Geological Agency dedicated for preparing basic scientific information for state policy planning. It is possible to improve the sectoral laws and regulations to resolve the urgent issue step by step by way of having a complex law package in the areas of geology, cadastral registration, labor and safety management and mining to cover the issues related to the sectoral specialties, the professional activities, the governmental and non-governmental organisations, the legal entities in the sector and the rights, duties and responsibilities of the qualified human resource.

-The public has different understanding about the development of the Oyu-Tolgoi gold and copper deposit, the Asgat silver deposit, the Gachuur gold deposit and the Salkhit silver deposit. Some of the local population and the civil society groups strictly protest against the development of these deposits?

- Systematic and step-by-step geological mapping and exploration programs are conducted and completed to discover a deposit to make it economically operational. It takes 20-30 years and requires substantial monetary investment. In addition, it provides the engineers, the technical personnel and the employees in the sector with jobs and incomes. The annual fees for exploration and mining licenses and the royalties for the minerals extracted from the deposits according to the approved feasibility studies account for the majority percent of the state budget revenue. Such revenues pay for pensions, social welfare allowances for the vulnerable groups in the society, salaries and wages to civil servants such teachers and doctors, and covers the costs for development projects in the country. An ordinary geologist or miner would not have such a big amount of money. Funds for this would not be allocated from the state budget, and therefore, the money from domestic and foreign investors are used for geological surveys and mineral mining and processing. It is even doubtful if it gives any profit at all based on the gap between the capital invested and the reserves approved. It is now required to take these issues into account based on calculations, researches and analyses.

тэтгэвэр, нийгмийн эмзэг бүлгийн тэтгэмж, багш, эмч зэрэг төрийн албан хаагчдын цалин, улс орны бутээн байгуулалтад зарцуулдаг ач холбогдолтой. Эгэл нэгэн геологич, уурхайчинд их хэмжээний мөнгө хөрөнгө байхгүй, улсын төсвөөс мөнгө хуваарилж өгдөггүй тул гадаад, дотоодын хөрөнгө оруулагчийн мөнгөөр геологийн судалгааны ажил, уул уурхайн олборлолт, боловсруулалтын ажлыг гүйцэтгэж байна. Зарцуулсан хөрөнгө, тогтоогдсон нөөцийн зөрүүгээр цэвэр ашиг гарч байгаа эсэх нь ч эргэлзээтэй байдаг. Эдгээр асуудлуудад тооцоо судалгаа, дун шинжилгээний үндсэн дээр хандах шаардлага байна.

-“Эрдэнэс Таван толгой” ХК-ийн хувьцааны талаар мэдээлэл өгнө үү?

-“Эрдэнэс Таван толгой” ХК-ийн хувьцааг хөрөнгийн зах зээлд бүртгүүлэх, арилжих, эргэлтэд оруулах замаар иргэдэд эзэмшүүлсэн 1072 хувьцааг үнэ цэнэтэй болгох ажлыг үе шаттай хэрэгжүүлж байна.

“Монголчуудын тэвчээрт хязгаар бий”

-Та Оюу толгойн гэрээнд шүүмжлэлтэй хандаж, үйл ажиллагааг зогсох ёстой гэсэн шаардлагыг тавьж байсан. Энэ юу болсон бэ?

-Өнөөдөр ч Оюу толгойн баялаг хороо цээрийн дэглэмийн энэ үед зогсолтгүй ачигдсаар байна. Харамсалтай нь харилцан ашигтай бус дан ганц талын ашиг сонирхолд чиглэгдсэн гадны менежмент үйлчилж байгаад ард түмэн ихэд дургүйцэн хүлээн авч байгаа. Эцэг евгэдийнхөө үлдээсэн эх орон эд баялагга бусдаар мэдүүлж тэдний үйлдэл үйл ажиллагааг харж байгаа монголчуудын тэвчээрт хязгаар бий. Монгол Улсын Засгийн газрын улс орны нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт заасан стратегийн орд газруудыг эдийн засгийн эргэлтэд оруулж үр өгөөжийг нь нэмэгдүүлж хүн ардынхаа аж жарталтай сайн сайхан амьдралын зорилтыг хангах бодлогыг хэрэгжүүлэн


-Could you, please, update us on the Erdenes Tavan Tolgoi JSC shares?

- By way of listing and trading the shares of Erdenes TavanTolgoi JSC at a stock exchange, we are implementing step-by-step activities to add value to the 1072 shares owned by our citizens.

Patience of Mongolians has its limits.

-You have criticised the Oyu-Tolgoi Agreement and called for suspension of operation. What has happened?

-Even today in the middle of quarantine, the minerals from Oyu Tolgoi is continuously being transported out of our country. Unfortunately, the public greatly disapproves the foreign management that serves to the interest of a single party. It is not mutually beneficial. The Patience of Mongolians has its limits when they see the actions of others managing their land and minerals handed down by their ancestors. We are implementing policies to make the strategic deposits, stated in the Action Plan of the Mongolian Government for the social and economic development of the country, operational to increase their benefits, and meet the goals to ensure that our citizens live happy. Within this framework, it is required to make changes into the shareholder's agreement of Oyu Tolgoi to meet mutual interests. However, it has been delayed by Rio Tinto for a long time. In this situation, it will only be possible to sit together at the table for negotiations by way of suspending their operations using the advantages of our sovereign country. There is an abundance of things we can learn from Rio Tinto; its investment, their international market and mining experiences and the expertise of their underground mining professionals. In general, the opportunity for the mutually beneficial cooperation is very simple. First, they can transfer the mine management to our side. With the advantages of their investment, the equipment and the professional workforce, they can operate as a contractor. After a certain period, they can fully recoup the costs incurred in proportion to their 66% ownership. Second, they can negotiate to pay our side 20% royalty. They can manage the mine themselves and acquire our 34%. In this



Монгол, Хятад, Оросын Түмэн газрын цайны зам дагуу хотуудын дарга нарын VI чуулга уулзалт БНХАУ-ын Хунань муж, Анхуа хот, Монгол Улсын төлөөлөгчдийн хамт 2018.10.27

ажиллаж байна. Энэ хүрээнд “Оюу толгой”-н хөрөнгө оруулалт хувь нийлүүлэгчдийн гэрээнд өөрчлөлт оруулж харилцан эрх ашгийг хангах шаардлага байгаа юм. Гэтэл “Рио тинто” компаницааргалсаар удаж байна. Ийм нөхцөл байдалд бид тусгаар улсынхаа давуу талыг харуулж үйл ажиллагааг нь зогсоож байж хэлэлцээрийн ширээний ард суух боломж бүрдэнэ. “Рио тинто” компанийн манай улсад оруулж байгаа хөрөнгө оруулалт, тэдний олон улсын зах зээл, уул уурхай тэр тусмаа гүний уурхайн бүтээн байгуулалт мэргэжилтэй ажилчдын туршлагаас манайд суралцаж дадлагажих зүйл их бий. Ер нь харилцан ашигтай байдлаар хамтарч ажиллах боломж их энгийн. Нэгдүгээрт, тэд уурхайн менежментийг манай талд шилжүүлж өөрсдийн хөрөнгө оруулалт техник тоног төхөөрөмж мэргэжилтэй боловсон хүчиний давуу талаа түшиглэн оператор компанийн үүрэг гүйцэтгэн тодорхой хугацааны дараа өөрсдийн бүх хувьд ногдох ашиг гаргасан зардлаа олж авах бүрэн боломжтой. Хоёрдугаарт, манай талд 20 хувийн роялти төлөхөөр тохирч өөрсдөө менежментээ зохион байгуулж манай 34 хувийг авч болно. Энэ тохиолдолд уурхайн бүх зардал санхүүжилт бидэнд хамаагүй болж манай 34 хувьд ногдох өр тэглэгдсэн байх ёстой.

-Хүнд үйлдвэрээ дагасан бүтээн байгуулалтын ажлуудын хэрэгжилт ямар байгаа вэ?

-Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас “Эрдэнэс Монгол” компани болон Оюутолгой төслийн үйл ажиллагааг эрчимжүүлж, Үндэсний геологийн алба байгуулах, Тавантолгой, стратегийн ач холбогдол бүхий бусад ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах, “Алт-2” хөтөлбөрийг боловсруулан батлуулах, газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах, зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэр байгуулах зорилт, арга хэмжээг хэрэгжүүлсэн. Үүний үр дүнд Хүнд үйлдвэрээ дагасан бүтээн байгуулалтын ажлууд бодитоор хэрэгжиж эхэлсэн.

Эдгээр зорилт, аргахэмжээг хэрэгжүүлснээр Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг хөрөнгийн зах зээлд бүртгүүлэх, арилжих, эргэлтэд оруулах замаар иргэдэд эзэмшүүлсэн 1072 хувьцааг үнэ цэнэтэй болгох; улсын төсвийн орлого бүрдүүлэлтийг тогтвортой байлгах, нэмэгдүүлэх; нутаг дэвсгэрийн хэмжээнд хийгдсэн геологийн иж бүрэн, үе шаталсан, системтэй судалгааны ажлын мэдээлэлээр хэтийн төлөвтэй объектыг шинээр илрүүлэх, ашигт малтмалын баялаг, нөөцийн хэмжээг нэмэгдүүлэх зэрэг олон асуудлуудыг шийдвэрлэнэ. Түүнчлэн ашигт малтмалын ихээхэн хэмжээний нөөцөд түшиглэсэн уулын баяжуулах, боловсруулах үйлдвэр бүс нутгуудад шинээр баригдахад ажилтан ажилласгад нь гэр бүлийн хамт урт хугацаагаар суурьшин амьдарч, цэцэрлэг, сургууль, эмнэлэг, худалдаа, үйлчилгээтэй Засаг захирагааны нэгжтэй “Эрдэнэт хот” шиг суурин газар байгуулах боломжтой. Мөн ундын, үйлдвэржилтийн болон хөдөө аж ахуйн усжуулалтын ус, барилгын материал, гүнд байрших хөндийлж /нухжилт/, цэвдэгшлийн зэрэг хот суурин газрын төлөвлөлт, дэд бүтцийн шинжлэх ухааны суурь мэдээллийг бүрдүүлж, эдийн засгийн ач холбогдол өндөртэй гоёлын алмаз, цагаан алт, газрын тос, байгалийн хийн хэтийн төлөвтэй обьектуудыг шинээр нээн илрүүлж, бүс нутгуудад бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлснээр ажлын байр олноор бий болгож, нийслэл дэх хүн амын төвлөрөл, ажилгүйдэл ядуурлыг бууруулан, ард түмний амьжиргааны түвшинг бодитоор дээшлүүлэх нөхцөл бүрдэж, улс орны хөгжлийг хурдаасана.

-Бидэнтэй ярилцсан танд баярлалаа.




case, all mine costs and financing will be out of our responsibility. The debt in proportion to our 34% must be nullified.

-What are the stages of implementation of the developments around the heavy industry?

-The Ministry of Mining and Heavy Industry has implemented the goals and measures for intensifying the projects of Erdenes Mongol LLC and Oyu Tolgoi LLC, founding a National Geological Agency, making the strategically important deposits such as Tavantolgoi economically operational, approving the Gold-2 Program, founding a petroleum processing plant as well as a copper melting and purifying plant. As a result, new developments around the heavy industry have started realising concretely.

By implementing these goals and measures, many issues will be resolved. These include the listing and trading of the shares of Erdenes Tavantoglo JSC at a stock exchange to bring added value to the 1072 shares owned by the public; the stabilising and increasing of the state budget revenue generation; the discovering of new strategic objects based on results of complex, step-by-step and systematic geological surveys conducted across the territory; and the increasing of the mineral resources and reserves. Furthermore, it will be possible, when mining, concentration and processing plants are built in regions with substantial mineral reserves, to build an urban area like Erdenet, a city with an administrative unit to provide long-term settlement opportunities to accommodate the employees and their family members with schools, kindergartens, hospitals, markets and service centers. In addition, the collection of basic scientific information about drinking, industrial and agricultural irrigation water, construction materials, underground glacier and permafrost for urban and infrastructural planning, the discovery of strategic luxury diamond, white gold, petroleum and natural gas deposits, and the commencement of development projects in regions will create job positions in a great number to reduce urban centralisation and poverty. All of these will offer the opportunity to concretely improve the livelihood of the population to further accelerate the development of the country.

-Thank you for your interview with us.



TIME TO WANDER

Бүх зүйл сайхан болсоны дараа аялалд гарахсан. Хөдөө машиныхаа хамар дээр суугаад нар жаргахыг харахсан. Тэр үед зөөлөн салхи хүзүү гижигдэж, цэцгийн үнэр хамар цоргино. Нүдээ анихад нарны улбар туяа зовхи нэвт тусахыг төсөөльье. Бодоход л дулаахан илчтэй.